



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 125

Төрийн ордон, Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ХИЙХ  
ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЦАГЛАВАР БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1."Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар"-ыг хавсралтаар баталсугай.
- 2."Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар"-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байнгын хороодын дарга нарт, мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус даалгасугай.
- 3.Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгуулах саналаа 2026 оны хаврын ээлжит чуулган завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэхийг Байнгын, дэд хороонд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.УЧРАЛ**